



ДЭРЭН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.ЦОГТ-ОЧИР ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.02.17 № 01/25 ДУА - 2017/63/СТА - ТШЗ

Г Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын 1.9, аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Дэрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2016 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрлын аудитаар нийт 8,887,844.20 /найман сая найман зуун наян долоон мянга найман зуун дөчин дөрвөн төгрөг хорин мөнгө/ төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Аудитын хамрах хугацаанд нийт 8,887,844.20 төгрөгийн хүнсний материалыг орцын жишиг нормоор бодоогүй, хяналтгүй зарцуулж зардалд тайлагнасан байна.

Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2014 оны 113 тоот тушаалаар баталсан ... хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ, Төсвийн тухай хуулийн 6.4.1-т /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах/ заасныг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зорчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах судитор, ахлах шинжээч, судитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зорчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1-д /Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, эсурам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлоөгүй / заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Холбогдох журам, жишиг орцын нормын дагуу хүнсний материалын зарцуулалтанд хяналт тавих, сар бүр тооцоо бодож баримтжуулж хэвших.

000000054

2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2016 оны 12 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Дэрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Б.Цогт-Очир, нягтлан бодогч П.Оюунчимэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

АХЛАХ АУДИТОР  Б.ГАНТУЯА

ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХИРАЛ  Б.ЦОГТ-ОЧИР
НЯГТЛАН БОДОГЧ  П.ОЮУНЧИМЭГ

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрээт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.